



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ №7

НЭГ. Шувууны томуугийн А хүрээний вирусийн шувууны өвчлөлийн хураангуй мэдээлэл:

2020 оны 4 дүгээр сарын 13-27-ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Вьетнам, Болгар, Унгар, Тайвань зэрэг улс орны шувууны аж ахуйд илрээд байна. Вьетнамд 10 удаагийн өвчлөл бүртгэгдэж 2221, Болгар улсад 2 удаа өвчлөл бүртгэгдэж 1345, Унгар улсад 9 удаагийн өвчлөл бүртгэгдэж 85415, Тайвань улсад 3 удаагийн өвчлөл бүртгэгдэж 16001 тэжээмэл шувууд өвчилж үхсэн байна (хүснэгт 1, зураг 1).

H16N3 вирусын дэд хэв шинж анх 1975 онд судлагдсан ба сүүлийн жилүүдэд зэрлэг шувуунд илэрч эхлээд байна. БНХАУ-ын Харбины Биотехнологи Мал Эмнэлгийн Лабораторийн судлаачдын үзэж байгаагаар энэхүү H16N3 вирус нь зэрлэг шувуунд болон хүнд халдварлах боломжтой гэж үзсэн байна. Энэхүү судалгааг 2017 оноос 2019 оны хооронд БНХАУ-д шувуунд H16N3 вирусээр өвчилсөн тохиолдлуудыг судалж, дүгнэлт гаргасан. Шувууны томуу нь “КОВИД-19” халдвараас 10 дахин илүү буюу үхлийн зэрэг нь 60 хувьтай байдаг.

ХОЁР. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 4 дүгээр сарын 13-27-ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй.

ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

Мөн хугацаанд шувууны томуугийн А хүрээний H5N6 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн тохиолдол шинээр бүртгэгдээгүй.

ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 4 дүгээр сарын 13-27-ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

ТАВ. Шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 4 дүгээр сарын 13-27-ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

ЗУРГАА. Шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 4 дүгээр сарын 13-27-ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H7N4)

вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.


ДОЛОО. 2020 оны 4 дүгээр сарын 13-27-ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн шувууны мэдээлэл:

(Хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирусийн тархалт болон вирусийн хэлбэр

№	Шувууд өвчилж эхэлсэн өдөр	Хэлбэр	Улс	Муж	Өртсөн нийт шувуудын тоо	Үхсэн
1	25/02/2020	H5N6	Вьетнам	Хуа Бэн	12250	300
2	27/02/2020	H5N6	Вьетнам	Хай Наам	1555	330
3	2/3/2020	H5N6	Вьетнам	Нэн Бэн	260	30
4	2/3/2020	H5N6	Вьетнам	Бак Ний	281	20
5	2/3/2020	H5N6	Вьетнам	Бак Ний	2184	350
6	10/3/2020	H5N6	Вьетнам	Ханой	3567	650
7	27/03/2020	H5N6	Вьетнам	Ний Ан	1930	365
8	27/03/2020	H5N6	Вьетнам	Ний Ан	795	100
9	28/03/2020	H5N6	Вьетнам	Наам Дэн	700	41
10	28/03/2020	H5N6	Вьетнам	Туэньгуан	196	35
11	12/3/2020	H5N8	Болгар	Пловдив	39120	1120
12	5/3/2020	H5N8	Болгар	Карзали	16800	225
13	29/03/2020	H5N8	Унгар	Сонград	2900	219
14	8/4/2020	H5N8	Унгар	Сонград	18500	18500
15	17/04/2020	H5N8	Унгар	Бач Кишкун	615	6
16	17/04/2020	H5N8	Унгар	Бач Кишкун	10000	10000
17	17/04/2020	H5N8	Унгар	Бач Кишкун	1700	1700
18	17/04/2020	H5N8	Унгар	Бач Кишкун	11700	11700
19	17/04/2020	H5N8	Унгар	Бач Кишкун	10300	10300
20	17/04/2020	H5N8	Унгар	Бач Кишкун	10000	10000
21	16/04/2020	H5N8	Унгар	Бач Кишкун	19700	19700
22	13/04/2020	H5N5	Тайвань	Яншуй	9699	1075
23	9/4/2020	H5N5	Тайвань	Донгши	2028	371
24	6/4/2020	H5N5	Тайвань	Хуижиг	878	155

Эх сурвалж: Oie.int

(Зураг 1) Шувууны томуугийн А хүрээний вирусийн тархалт /зургаар/



ДОЛОО. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдлын мэдээлэл:

2020 оны 4 дүгээр сарын 13-27-ны хооронд шувууны томуугийн сэжигтэй буюу шувууд олноор үхсэн дуудлага бүртгэгдээгүй байна.

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Шувууны томуу хариуцсан баг